

**ХААЛТТАЙ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ХАДГАЛАМЖИЙН
БОЛОН ХУВЬЦААТАЙ ХОЛБОГДОЛТОЙ
ТӨЛБӨР ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

20... оны ... дүгээр
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас “ҮЦТХТ” ХХК /цаашид хадгалагч гэх/, нөгөө талаас хаалттай ХК /цаашид хадгалуулагч гэх/ бид /цаашид талууд гэх/ СЗХ-ны “Хаалттай ХК”-ийн хувьцааг бүртгэх, хадгалах, өмчлөх эрх шилжүүлэх, үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийг үндэслэл болгон харилцан тохиролцож, дор дурьдсан нөхцөлтэйгээр байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Гэрээний зорилго нь хадгалагч нь хадгалуулагчийн хүсэлтийн дагуу гаргасан хувьцааг нь хадгалах, хадгалуулагч хадгалагч талд хадгаламжийн үйлчилгээний хөлс төлөх, хадгаламжийн хугацаа, хадгаламжаас чөлөөлөх, хадгалуулсан хувьцаатай холбогдолтой төлбөрийг зуучлан гүйцэтгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**Хоёр. Хадгалуулах хувьцааны нэр, тоо ширхэг,
хадгаламжийн үйлчилгээний хөлс**

2.1 Хадгалуулагч нь хадгалагч талын хадгаламжид нэртэйширхэг хувьцааг хадгалуулах батөгрөгийн үйлчилгээний хөлсийг жил бүр төлнө.

2.2 Хадгаламжийн үйлчилгээний хөлсийг тухайн компанийн хувьцааны нэрлэсэн үнийг нийт зарласан хувьцааны тоо ширхэгээр үржүүлсэн үнийн дүнгээс журмын 1 дүгээр хавсралтын дагуу тооцно.

Гурав. Хувьцаа хадгалах хугацаа

3.1 Хадгаламжийн гэрээ нь үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлээс хасагдах хүртэл хугацаанд хүчинтэй.

3.2 Хадгаламжийн гэрээний хугацаа нь тухайн гэрээ байгуулсан жилдээ хүчин төгөлдөр байна.

3.3 Талууд харилцан тохиролцож хадгаламжийн хугацаанд нэмэлт өөрчлөлт оруулж болох ба энэ тухай хүсэлтээ гэрээний хугацаа дуусахаас 1 сарын өмнө нөгөө талдаа мэдэгдэнэ.

Дөрөв. Хувьцаатай холбогдолтой төлбөрийг зуучлан гүйцэтгэх

4.1 Хувьцааны хадгаламжийн үйл ажиллагааг “Хаалттай хэлбэрээр гаргасан хувьцааг бүртгэх, хадгалах, өмчлөх эрхийг шилжүүлэх журам”-аар зохицуулна.

4.2 Хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй бүртгэл нээж, хувьцаатай холбогдолтой төлбөрийг шударга, ил тод, шуурхай хийж гүйцэтгэнэ.

Тав. Хадгалуулагчийн эрх, үүрэг

5.1 Хадгалуулагч дараах эрх, үүрэгтэй :

5.1.1 Хадгалагчийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавих эрхтэй.

5.1.2 Хуваарилсан ногдол ашиг /болон ногдол хувь/-ийг хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн дагуу тараалгах эрхтэй.

5.1.3 Хадгалуулагч нь Санхүүгийн Зохицуулах Хорооны “Хаалттай хувьцаат компанийн журам”-ын 5.5-д заасны дагуу ногдол ашгаа компани дээрээ тарааж байгаа тохиолдолд хадгалагч талд албан бичгээр мэдэгдэнэ.

5.1.4 Хувьцааны гүйлгээ, үнэ ханш, арилжааны хэмжээ, явцад нөлөөлөх мэдээ, компанийн болон удирдлагын үйл ажиллагааны талаар шударга, шуурхай хүргэх үүрэгтэй.

5.1.5 Хадгаламжийн үйлчилгээний хөлсийг төлөх үүрэгтэй.

5.1.6 Хадгалуулагч тал нь хувьцааны бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасагдах тохиолдолд хадгалагч талаас өр төлбөрийн тооцоо болон бүртгэлээс хасахад татгалзах зүйлгүй тухай тодорхойлолтыг албан бичгээр авч Оюуны Өмч, Улсын Бүртгэлийн Ерөнхий газарт хүргүүлэх үүрэгтэй.

Зургаа. Хадгалагчийн эрх, үүрэг

6.1 Хадгалагч дараах эрх үүрэгтэй :

6.1.1 Хадгалагдаж буй хувьцааны бүрэн бүтэн байдлыг хангах үүрэгтэй.

6.1.2 Гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг хангах үүрэгтэй.

6.1.3 Хувьцаатай холбогдолтой төлбөрийг зуучлан гүйцэтгэх үүрэгтэй.

6.1.4 Хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй бүртгэлийг хувьцаа эзэмшигчийн овог нэр, оршин суугаа хаяг, эзэмшиж буй хувьцааны тоо ширхэгээр хөтлөх үүрэгтэй.

6.1.5 СЗХ-ны “Хаалттай хувьцаат компанийн хувьцааг бүртгэх, өмчлөх эрх шилжүүлэх үйл ажиллагааны журам”-ын 5.3-д заасан хугацаанд хувьцааны шилжилт хөдөлгөөнийг бүртгэх үүрэгтэй.

6.1.6 Хадгалуулагчийн хүсэлтээр хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй бүртгэлийг үнэн зөв, шуурхай гаргаж өгөх үүрэгтэй.

6.1.7 Хуваарилсан ногдол ашиг /болон ногдол хувь/-ийг хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг гаргаж, гэрээ байгуулах үүрэгтэй.

6.1.8 Хадгаламжийн болон бусад холбогдох үйл ажиллагааны журамд орсон нэмэлт өөрчлөлтүүдийг тухай бүр хадгалуулагчид мэдэгдэх үүрэгтэй.

6.1.9 Хадгаламжийн үйлчилгээний хөлс төлөхийг шаардах эрхтэй.

Долоо. Талуудын хариуцлага

7.1 Хадгалагч хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй бүртгэлийн үнэн зөвийг хариуцна.

7.2 Хадгалуулагчийн буруугаас шалтгаалан гэрээ цуцлагдсан бол түүнээс үүдэн гарах хохирлыг хадгалагч хариуцахгүй.

Найм. Гэрээ дуусгавар, болох буюу түүнийг цуцлах

8.1 Гэрээний нөхцөл бүрэн биелэгдсэн, хадгалуулагч хувьцаагаа хадгаламжаас хасуулах тухай хүсэлт гаргаж хувьцааг дэлгэрэнгүй бүртгэлээс хассанаар гэрээ дуусгавар болно.

8.2 Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ аль нэг тал биелүүлээгүй дараах үндслэлээр гэрээг хугацаанаас өмнө цуцлуулахаар нөгөө тал хүсэлт гарган өөрт учирсан хохирлоо нэхэмжлэх эрхтэй.

8.2.1 хадгалуулсан хувьцааны бүрэн бүтэн байдлыг хангаагүй;

8.2.2 хувьцаатай холбогдолтой төлбөрийг зуучлан гүйцэтгээгүй;

- 8.2.3 хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй бүртгэл хөтлөөгүй;
- 8.2.4 хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй бүртгэлийг буруу гаргасан;
- 8.2.5 хадгалуулагч хувьцаа хадгалуулах талаар хүсэлтдээ хуурамч мэдээ, материал хавсаргасан нь тогтоогдсон;
- 8.2.6 хадгаламжийн үйлчилгээний хөлс төлөхөөс татгалзсан;

Ес. Бусад

9.1 Гэрээ талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

9.2 Энэхүү гэрээг 2 эх хувь үйлдэж, хоёр тал тус бүр нэг хувийг хадгалсан нь хуулийн адил хүчинтэй байна.

9.3 Энэхүү гэрээг хэрэгжүүлэх явцад гарах аливаа маргааныг талууд эв зүйгээр зөвшилцөлд хүрэх замаар шийдвэрлэх ба зөвшилцөлд хүрч чадахгүй бол шүүхэд хандан шийдвэрлүүлнэ.

9.4 Гэрээнд нэмэлт өөрчлөлт нь гагцхүү бичгээр үйлдэгдэж, талуудын бүрэн эрхт төлөөлөгч нар гарын үсэг зурсан тохиолдолд хүчин төгөлдөр гэж тооцогдоно.

9.5 Ийнхүү шийдвэрлэсэн нэмэлт, өөрчлөлт нь энэхүү гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Хадгалагчийг төлөөлж:

“ҮЦТХТ”ХХК-ийн
ХӨЭБКА-ны захирал

.....

/...../

Хаяг: Чингэлтэйдүүрэг, 4 хороо
Самбуугийн гудамж 16/1
Утас: 70113671
Факс: 976-70114424

Э-мэйл: info@mcsd.mn

Хадгалуулагчийг төлөөлж:

.....хаалттай ХК-ийн
Гүйцэтгэх захирал

.....

/...../

Хаяг:
.....
Утас:
Факс:

Э-мэйл:

Батлав. “ҮЦТХТ” ХХК-ийн
Гүйцэтгэх захирал

Батлав. “.....” хаалттай ХК-ийн
Гүйцэтгэх захирал

..... /...../

..... /...../

**“ҮЦТХТ” ХХК-ИАР ЗУУЧЛУУЛАН
НОГДОЛ АШИГ ТАРААХ ГЭРЭЭ**

20.. оны сарын -ний өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг Монгол Улсын Компанийн тухай хуулийн 47-р зүйл, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 42, 45-р зүйл, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн “Хадгаламжийн журам”, компанийн хүсэлтийг үндэслэн нэг талаас Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 хороо, Самбуугийн гудамж 16/1 хаягт орших “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /цаашид зуучлагч гэх/, нөгөө талаас “.....” компани /цаашид компани гэх/ нар дараах нөхцөлийн талаар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Ерөнхий нөхцөл

1. Энэхүү гэрээний зорилго нь хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг зуучлагчаар дамжуулан тараахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.
2. Гэрээг зөвхөн компаниас ирүүлсэн жагсаалтын дагуу ногдол ашгийг тараахаар байгуулна.
3. Ногдол ашгийн мэдэгдэл /хавсралт 1/, “.....” ХК-аас ногдол ашиг тараахад компаниар тараалгасан хувьцаа эзэмшигчдийн жагсаалт /Хавсралт 2/ нь гэрээний салшгүй хэсэг байна.

Хоёр. Компанийн эрх, үүрэг

4. Нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээ, бүртгэх өдөр болон ногдол ашиг тарааж эхлэх өдөр, ногдол ашгийг зуучлагчаар дамжуулан тараах тухай хувь нийлүүлэгчдэд мэдэгдэнэ.
5. Гэрээнд гарын үсэг зурснаас хойш ажлын 3 хоногт багтаан ногдол ашгийг “ҮЦТХТ” ХХК-ийн банкин дахь тоот дансанд, үйлчилгээний хөлсийг банк дахь тоот харилцах дансанд шилжүүлнэ.
6. Зуучлагчид гаргаж өгсөн ногдол ашгийн жагсаалтаас өөрөөр маргаан үүссэн тохиолдолд уг маргааныг бие даан шийдвэрлэнэ.
7. Зуучлагчийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавих эрхтэй.
8. Ногдол ашиг тараагдсан тухай тайлан, дэлгэрэнгүй бүртгэл гаргуулан авах эрхтэй.

Гурав. Зуучлагчийн эрх, үүрэг

9. Ногдол ашгийн мөнгө зуучлагчийн харилцах дансанд орсноос хойш ажлын 3 хоногт багтаан жагсаалтыг үндэслэн хувь нийлүүлэгчдийн төвлөрсөн хадгаламжийн дансанд шилжүүлнэ.
10. Хувьцаа эзэмшигчдийн дансанд ногдол ашгийг шилжүүлсэн тухай дэлгэрэнгүй мэдээг гаргана.

Дөрөв. Талуудын хариуцлага

11. Ногдол ашгийн мөнгийг хувьцаа эзэмшигчийн анхны хүсэлтээр гаргаж өгөөгүй тохиолдолд хувьцаа эзэмшигчийн нэхэмжлэлээр зуучлагч нь хоног тутам 0.3%-ийн алданги төлнө. Ногдол ашгийн мөнгө нь зуучлагчийн дансанд хугацаандаа орж ирээгүй тохиолдолд алдангийг компани хариуцана.
12. Ногдол ашгийн мэдэгдэл, ногдол ашиг компаниас авсан хувь нийлүүлэгчдийн бүртгэлийн үнэн зөвийг компани хариуцна.

Тав. Бусад зүйл

13. Энэхүү гэрээг хэрэгжүүлэх явцад гарах аливаа маргааныг компани болон зуучлагч юуны түрүүнд эв зүйгээр хэлэлцээр хийх замаар шийдвэрлэнэ.
14. Хэлэлцээр хийх замаар шийдвэрлэж чадаагүй бол маргааныг шүүхийн журмаар шийдвэрлүүлнэ.
15. Энэхүү гэрээ нь талуудын бүрэн эрхт төлөөлөгч нар гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
16. Энэ гэрээг 2 эх хувь үйлдэж, хоёр тал тус бүр нэг хувийг хадгалсан нь хуулийн адил хүчинтэй байна.
17. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах бол гагцхүү бичгээр үйлдэгдэж, талуудын бүрэн эрхт төлөөлөгч нар гарын үсэг зурсан тохиолдолд хүчин төгөлдөр гэж тооцогдоно. Ийнхүү шийдвэрлэсэн нэмэлт өөрчлөлт нь энэхүү гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.
18. Гэрээтэй холбоотой бүхий л мэдэгдэл, зөвлөлгөө, хүсэлтийг Талууд бичгээр дараах албан ёсны хаягаар илгээнэ.

Хэрэв зуучлагч байгууллагад хүргүүлэх бол

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 хороо, Самбуугийн гудамж 16/1, Утас : 70113671, Факс : 70114424

Мэдэгдэл хүргүүлэх эрх бүхий албан тушаалтан :

Хадгаламж, өмчлөх эрх бүртгэлийн албаны захирал

Компанид хүргэх бол "....." хаалттай ХК

Хаяг :

Мэдэгдэл хүргүүлэх эрх бүхий албан тушаалтан :

.....

Утас:

Гэрээ байгуулсан:

“ҮЦТХТ” ХХК-ийг төлөөлж:

“

” хаалттай ХК-ийг төлөөлж:

ХӨЭБКА-ны захирал

НОГДОЛ АШГИЙН МЭДЭГДЭЛ

1. КОМПАНИЙН НЭР “.....” хаалттай ХК
2. ХАЯГ
3. ХАРИЛЦАХ УТАС
4. ШИЙДВЭР ГАРСАН ОГНОО
5. ОЛОН НИЙТЭД ЗАРЛАСАН ОГНОО
6. ОЛОН НИЙТЭД ЗАРЛАСАН ХЭЛБЭР
7. БҮРТГЭХ ӨДӨР
8. БҮРТГЭГДСЭН ХУВЬЦААНЫ ТОО
9. НЭГЖ ХУВЬЦААНД НОГДОХ НОГДОЛ АШГИЙН ХЭМЖЭЭ
10. “ҮЦТХТ” ХХК-иар ЗУУЧЛУУЛАН ТАРААХ
 - А. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ТОО
 - Б. ХУВЬЦААНЫ ТОО

11. “ҮЦТХТ” ХХК-иар ЗУУЧЛУУЛАН ТАРААХ

НИЙТ ДҮН / 9 *10Б / ₮

12. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС /40 000 төг/ ₮

14. НИЙТ ШИЛЖҮҮЛЭХ МӨНГӨНИЙ ДҮН /11+12/ ₮

Мэдэгдэл гаргасан

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ / /

МЭДЭГДЭЛ ГАРГАСАН ОГНОО

Мэдэгдлийг хүлээн авсан

ҮЦТХТ-ийн ХӨЭБКА-ны ажилтан / /

“ ” хаалттай ХК дээр ногдол ашиг авсан
хувьцаа эзэмшигчдийн жагсаалт

Д/д	Данс	Овог нэр	Регистр	Тоо ширхэг
1				
2				
3				
4				
5				
6				
	Нийт			

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

..... /...../

ХУВЬЦАА ХАДГАЛАМЖИД БҮРТГЭХ ЗӨВШӨӨРӨЛ №

..... хаалттай хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 20... оны сарынөдрийн тогтоол, “ҮЦТХТ” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 20.. онысарынөдрийн тоот тогтоолын дагуу дараах хувьцааг бүртгэхийг зөвшөөрөв.

Үзүүлэлт		Хувьцааны бүртгэл
Хувьцааны код:		
Хувьцааны нэр:		
Хувьцааны төрөл:		
Нийт хувьцааны тоо : /ширхэг/		
Төр	Гоо /ширхэг/	
Орон нутаг		
Хувьцаа эзэмшигч	Хувь /%/	
Нэрлэсэн үнэ: /төгрөг/		
Хувьцааны нийт үнийн дүн: /төгрөг/		

ХӨЭБКА-НЫ АЖИЛТАН

ХӨЭБКА-НЫ ЗАХИРАЛ

ХУВЬЦАА ХАДГАЛАМЖААС ХАСАХ ЗӨВШӨӨРӨЛ №

..... хаалттай хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 20...
 оны сарын өдрийн тогтоол, “ҮЦТХТ” ХХК-ийн гүйцэтгэх захирлын
 20.. оны сарын өдрийн тоот тогтоолын дагуу дараах хувьцааыг бүртгэлээс
 хасахыг зөвшөөрөв.

Үзүүлэлт		Хувьцааны бүртгэл
Хувьцааны код:		
Хувьцааны нэр:		
Хувьцааны төрөл:		
Нийт хувьцааны тоо : /ширхэг/		
Нэрлэсэн үнэ: /төгрөг/		
Хувьцааны нийт үнийн дүн: /төгрөг/		
Ногдол ашиг тараасан эсэх:		
Тараасан бол	Тараасан онууд:	
	Нэгж хувьцаанд ногдох хэмжээ: /төгрөг/	
Хувьцаа эзэмшигчийн тоо:		

ХӨЭБКА-НЫ АЖИЛТАН

ХӨЭБКА-НЫ ЗАХИРАЛ

ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС

Хувьцааны үнэлгээний шатлал	Үйлчилгээний хөлс
0-100,0 сая хүртэл	1,500,000₮
100,001 - 400,0 сая төг	2,250,000₮
400,001 - 700,0 сая төг	3,000,000₮
700,001 - 1000,0 сая төг	3,750,000₮
1,000,0001 тэрбум төгрөгөөс дээш	4,500,000₮

МЭДЭЭ, СУДАЛГААНЫ ТӨЛБӨР

Мэдээний нэр	Үйлчилгээний хөлс
Хувьцаа эзэмшигчдийн товчоо	Суурь хураамж 60 000 төг + хуудасны үнэ 100 төг
Годорхой хувь болон ширхэгийн судалгаа	20 000 төг + хуудасны үнэ 100 төг
Хувьцаа эзэмшлийн тодорхойлолт	5 000₮
Хувьцаа эзэмшигчдийн хураангуй судалгаа	1 000₮+ хуудасны үнэ 100 төг
Ногдол ашиг, ногдол хувь тараалгах үйлчилгээний хураамж	40 000₮

**ХУВЬЦААГААР ГЭРЧЛЭГДСЭН ӨМЧЛӨХ ЭРХ
БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС**

Төрөл	Үйлчилгээний хөлс
Шинэ данс – Иргэн	2 000 төгрөг
Шинэ данс - Хуулийн этгээд	20 000 төгрөг

Гүйлгээний төрөл	Үйлчилгээний хөлс /үнийн дүнгээс/
Худалдах худалдан авах гэрээний дагуу өмчлөх эрх шилжүүлэх	Худалдсан, худалдан авсан 2 талаас гүйлгээний үнийн дүнгээс 0.3 хувь
Гэрээслэл, өв залгамжлалаар өмчлөх эрх шилжүүлэх	Нэрлэсэн үнийг шилжүүлж буй хувьцааны тоогоор үржүүлсэн дүнгээс 1 хувь
Бэлэглэлийн гэрээгээр өмчлөх эрх шилжүүлэх	Нэрлэсэн үнийг шилжүүлж буй хувьцааны тоогоор үржүүлсэн дүнгээс 3 хувь
Компани шинээр болон нэмж гаргасан хувьцааг нэр зааж эзэмшүүлэх	Эзэмшсэн талаас 0.1 хувь
Эрх бүхий байгууллагын болон шүүхийн шийдвэрийн дагуу өмчлөх эрх бусдад шилжсэнийг бүртгэх	Нэхэмжлэгч талаас 0.2 хувь
Гэрээ дүгнэсэн актын дагуу хувьцаагаар гэрчлэгдсэн өмчлөх эрх бусдад шилжсэнийг бүртгэх	Үүрэг гүйцэтгүүлэгч талаас 1 хувь
Зээлийн барьцаанд хувьцаа тусгаарлуулсан хоног тутамд	Зээлдэгч талаас /Журмын 8-р хавсралтын дагуу/

Хавсралт 4**МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ**

Дансны үлдэгдэл	Хэвлэмэлээр –200 төг
Дансны гүйлгээний хуулга	1 хуудас нь 200 төг
Бусад зөвшөөрөгдсөн, боловсруулалт хийгдсэн мэдээ мэдээлэл	1 хуудас нь 1000 төг

ҮҮРГИЙН ГҮЙЦЭТГЭЛ ХАНГАХТАЙ ХОЛБООТОЙ ШИМТГЭЛ

50 сая хүртэл төгрөг	0.001 хувь
50 саяас 100 сая хүртэл төгрөг	Суурь 500 төгрөг дээр 50 саяас давсан дүнгийн 0.0009 хувиар
100 саяас 150 сая хүртэл төгрөг	Суурь 950 төгрөг дээр 100 саяас давсан үнийн дүнгийн 0.0008 хувиар
150 саяас 200 сая хүртэл төгрөг	Суурь 1 350 төгрөг дээр 150 саяас давсан үнийн дүнгийн 0.0007 хувиар
200 саяас 250 сая хүртэл төгрөг	Суурь 1 700 төгрөг дээр 200 саяас давсан үнийн дүнгийн 0.0006 хувиар
250 саяас 300 сая хүртэл төгрөг	Суурь 2 000 төгрөг дээр 250 саяас давсан үнийн дүнгийн 0.0005 хувиар
300 саяас 350 сая хүртэл төгрөг	Суурь 2 250 төгрөг дээр 300 саяас давсан үнийн дүнгийн 0.0004 хувиар
350 саяас 400 сая хүртэл төгрөг	Суурь 2 450 төгрөг дээр 350 саяас давсан үнийн дүнгийн 0.0003 хувиар
400 саяас 450 сая хүртэл төгрөг	Суурь 2 600 төгрөг дээр 400 саяас давсан үнийн дүнгийн 0.0002 хувиар
450 саяас 500 сая хүртэл төгрөг	Суурь 2 700 төгрөг дээр 450 саяас давсан үнийн дүнгийн 0.0001 хувиар
500 саяас 550 сая хүртэл төгрөг	Суурь 2 750 төгрөг дээр 500 саяас давсан үнийн дүнгийн 0.00009 хувиар
550 саяас 600 сая хүртэл төгрөг	Суурь 2 795 төгрөг дээр 550 саяас давсан үнийн дүнгийн 0.00008 хувиар
600 саяас 650 сая хүртэл төгрөг	Суурь 2 835 төгрөг дээр 600 саяас давсан үнийн дүнгийн 0.00007 хувиар
650 саяас 700 сая хүртэл төгрөг	Суурь 2 870 төгрөг дээр 650 саяас давсан үнийн дүнгийн 0.00006 хувиар

**Хувьцаагаар гэрчлэгдэх өмчлөх эрхээр үүргийн гүйцэтгэл
хангахыг зөвшөөрсөн тухай батламж №**

Үүргийн гүйцэтгэлийн төрөл _____

“ҮЦГХТ”ХХК-ийн төвлөрсөн хадгаламжид бүртгэлтэй хувьцаааар гэрчлэгдэх өмчлөх эрхээр үүргийн гүйцэтгэлийг хангахаар харилцан тохиролцож гэрээ байгуулсан тухай батламж гаргаж байна.

Дор дурьдсан харилцагчийн дараах хувьцааны гүйлгээг батламж гаргасан өдрөөс эхлэн 200.. он .. сар .. өдрийг хүртэл ... хоногийн хугацаагаар тусгаарлаж хадгалахыг хүсье.

Д\д	Харилцагч нэр	Данс дугаар	Хувьцааны нэр,төрөл	Тоо,ширхэг

/ тоогоор, үсгээр бичих /

.....
.....

БАТЛАМЖ ГАРГАСАН

Үүрэг гүйцэтгэгч

Үүрэг гүйцэтгүүлэгч

Овог нэр

Овог нэр

Регистрийн дугаар
Дансны дугаар

Регистрийн дугаар
Дансны дугаар

Гарын үсэг _____

Гарын үсэг _____

20. . он. . . сар. . . өдөр

Нотариатын батламж

Батламжийг хүлээн авч гүйлгээ хийсэн ХӨЭБКА-ны ажилтан.....